



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/176

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сэдэджамцын Ганбаатар (CP62071115) газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөж авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан өв залгамжлагч иргэн Жамсрангомбын Оюунбилэг /CP62081505/-д өвөлжөө, хаваржааны зориулалттай газрыг 9 жилийн хугацаатай өвлүүлж эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний дагуу биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Жамсрангомбын Оюунбилэг-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 06 дүгээр сарын 30-ний A/108 дугаар захирамжийн Сэдэджамцын Ганбаатар-д холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.



Р.ЭНХТӨР

Хүмүүнлэг Засаг даргын 2015-09-29-ны дүгээр захирамжийн хатуу

[illegible]